

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



БАТДАВ

Э.АНХБАЯР

2020 оны 02 дугаар сарын 18-ний өдрийн
51 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

ТӨРИЙН ӨӨРИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН ТҮРЭЭСЛЭГЧИЙГ СОНГОХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЫН МАЯГТ

1. Түрээслэх эд хөрөнгийн танилцуулга

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн автомашины төлбөртэй зогсоолыг түрээслэн ажиллуулах түрээслэгчийн сонгон шалгаруулалт зарлаж байна. Нийт 150 автомашины 900 м² хүчин чадалтай тоног төхөөрөмж шинээр байршуулах гадна талбайг ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН 49-р тогтоолын хавсралт дахь 1мкв нь 10.000 /арван мянга/ төгрөгөөр авто зогсоолыг түрээслүүлнэ.

2. Сонгон шалгаруулалтын ерөнхий мэдээлэл

Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн хугацаа	2025 оны 04 дугаар сарын 18-ний өдрийн 10 цаг 00 минут
Материал хүлээн авах хаяг	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 14 дүгээр хороо Халдварт өвчин судлалын үндэсний төв захиргааны байр 2 давхарт 206 тоот.
Материал нээх хугацаа, хаяг байршил	Халдварт өвчин судлалын үндэсний төв захиргааны байр 2 давхарт 213 тоот 2025 оны 04 дугаар сарын 18-ний өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.
Эд хөрөнгө түрээслүүлэх үнийн доод хэмжээ	Автомашины нэг зогсоол нийт 150 автомашины 900 м ² хүчин чадалтай тоног төхөөрөмж шинээр байршуулах гадна талбай түрээсийн доод үнийг 9,000,000 /ёсөн сая/ төгрөг болно. Автомашины дугаар уншигч бүхий бүрэн автомат авто зогсоолын хаалтыг төв үүд болон хойд хаалганы орц, гарцанд байршуулж суурилуулах засвар үйлчилгээ хийх үнийн саналын хамт ирүүлнэ.
Түрээслэгч үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай	Шаардлагатай. Төвийн төлбөртэй зогсоолын дагаж мөрдөх журманд нийцүүлэн бичиг баримтыг бүрдүүлэх.

ЗӨВШӨӨРЛИЙН МЭДЭЭЛЭЛ	
Түрээслэгчийг сонгон шалгаруулах зааврын талаарх товч мэдээлэл	Эрхэлдэг үйл ажиллагааны чиглэлээр мэргэшсэн, туршлагатай, санхүүгийн чадвартай гэдгээ оролцогч өөрөө нотлох зорилгоор бүрдүүлэх материалыг бүрэн ирүүлнэ. Дутуу тохиолдолд үл маргах журмаар хасна.
Оролцогчдын бүрдүүлж ирүүлэх материал	<ol style="list-style-type: none"> Улсын бүртгэлийн гэрчилгээг баталгаажуулан хуулбарлан ирүүлэх Түрээсээр эзэмших ашигтай талбай болон нийтийн эзэмшлийн талбайд явуулах үйл ажиллагааны төлөвлөгөөний танилцуулга, ажлын туршлагын талаарх мэдээлэл (тухайн чиглэлээр 2-оос доошгүй жил үйл ажиллагаа явуулсан, ижил төстэй ажлын гэрээний хуулбар) ирүүлэх; Санхүүгийн чадварыг нотлох баримт: 2022, 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, татвар, нийгмийн даатгалын цахим тодорхойлолт; Ажиллах хүчиний мэдээлэл; Тухайн түрээслэж буй талбайн цэвэрлэгээ үйлчилгээг бүрэн хариуцах тухай тодорхойлолт; Түрээслэх үнийн санал; Авто зогсоолын хаалт суурилуулах талаар мэдээлэл, танилцуулга, зогсоолын хаалтын техникийн тодорхойлолт; Сонгон шалгаруулалтад оролцох хураамж 50,000 төгрөг /тавин мянган/ тушаасан баримт;

3. Нэмэлт шаардлага:

- 1 дүгээр пост:
 - ✓ Төв үүдний хэсгийн хэсэгчлисэн засварын ажил хийж гүйцэтгэх /Аюулгүй гарцын төмөр хашаг буулгах, зөөвөрлөх үлдсэн хэсэгт засвар хийх/
 - ✓ Тэмдэг тэмдэглэгээ нэмэлтээр хийх.
- 2 дугаар пост:
 - ✓ Шинээр пост бий болгох.
 - ✓ Тухайн цэгт ажиллах ажилтанд аюулгүй ажиллагаа, тохь тухтай байдлыг хангах.
 - ✓ Автомашины дугаар уншигч бүхий бүрэн автомат авто зогсоолын хаалтыг орц, гарцанд байршуулж суурилуулах засвар үйлчилгээ хийх.
3. Яаралтай болон тусгай тээврийн хэрэгсэл, ажилчдын автомашин үнэ төлбөргүй;
4. Талбайн өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээ, зохион байгуулалтын ажил хариуцах;
5. Гамшгийн ослын үеийн бэлэн байдал болон ХӨСҮТ-өөс зохион байгуулсан ажил арга хэмжээнд талбай чөлөөлөхийг хариуцах;

6. Онгоц буухад талбайн бэлэн байдлыг хариуцах;

Материалыг зарласан хугацаанд, байгууллагын нэр, өөрийн аж ахуй нэгжийн нэр, бүрдүүлсэн материалын жагсаалт тус бүрийг дугтуйны гадна талд бичиж битүүмжилсэн хэлбэрээр ирүүлнэ үү.

4. Түрээслүүлэх хөрөнгийн талаар мэдээлэл авах

Түрээслүүлэх хөрөнгийг өмч эзэмшигч Халдварт өвчин судлалын үндэсний төв дээр ирж үзэж болох бөгөөд сонгон шалгаруулалтын заавар, бүртгэх хугацаа, хөрөнгийн талаарх мэдээллийг ажлын цагаар 91090603, 99992294 дугаарын утсаар болон www.nccd.gov.mn цахим хуудаснаас авна уу.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14 дүгээр хороо өөрийн байр



ХАЛДВАРТ ӨВЧИН
СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2025 оны 01 сарын 13 өдөр

Дугаар A/19

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2001 оны 134 дүгээр тогтоол, 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 79 дүгээр тогтоол, 166 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 49, 51 дүгээр тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 16 дугаар тогтоолын хавсралт "Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн хэрэгцээний авто зогсоолыг төлөвлөх, барьж байгуулах журам"-ын 2.8, 3.1.3, 3.2 дахь заалт, Төвийн 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн Удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Тус төвийн гадна талбайн авто зогсоолын үйл ажиллааг зохицуулах журмыг баталсугай.

1. Журмыг 2025 оны 02 дугаар сарын 08-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Тус төвеөр үйлчлүүлж буй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэл, зогсоолд байршуулах орох, гарах, хэсэг хөдөлгөөний аюулгүй байдал, техник ашиглалт болон, үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нийт тээврийн хэрэгслийн жолооч нарт хамаарна.

3. Журмын хэрэгжилтийн гүйцэтгэлийг мэдээлж ажиллахыг Хангамж үйлчилгээ инженер технологийн албаны дарга (Н.Батням)-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Стратеги төлөвлөлт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал (Д.Бат-ундрах)-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Э.АНХБАЯР



**ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ГАДНА ТАЛБАЙН
АВТО ЗОГСООЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

АГУУЛГА

1. Зорилго	2
2. Холбогдох хууль, журам, тотгтоол	2
3. Нэр томьёо, тодорхойлолт	1-2
4. Төвийн эрх, үүрэг	3
5. Төлбөртэй зогсоолын үйлчилгээ эрхлэгчийн эрх, үүрэг	3-4
6. Төлбөртэй зогсоолоор үйлчлүүлэгчийн эрх, үүрэг	4
7. Авто зогсоол түрээслэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд тавих шаардлага	4-5
8. Журмын хэрэгжилтийн шалгуур	5

Зорилго:

Тус төвийн бүх төрлийн авто тээврийн хэрэгслийг орох, гарах хэсэгт зогсоолын хаалт байршуулан хөдөлгөөний аюулгүй байдал, техник ашиглалтын болон, галын аюулгүйн шаардлагыг хангах, үйлчлүүгчидэд таатай нөхцөл бүрдүүлж найрсаг үйлчилгээг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1. Холбогдох хууль, журам, тогтоол:

Энэхүү журамд дараах баримт бичгийн сүүлчийн хэвлэлийг үндэслэл болгон тусгаж, иш татан хэрэглэсэн болно. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /1996 оны 05-р сарын 27-ны өдөр/
- Авто замын тухай хууль /2016 оны 05-р сарын 11-ний өдөр/
- Засгийн газрын 2001 оны 06-р сарын 20-ны өдрийн 134 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам"
- Засгийн газрын 2016 оны 166, 79-р тогтоол/ Засгийн газрын 2001 оны 06-р сарын 20-ны өдрийн Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх журамд өөрчлөлт оруулсан.
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2009 оны 12-р сарын 23-ны өдрийн 4/27 тоот тогтоолоор батлагдсан "Нийтийн эзэмшлийн зам талбайд тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоол ажиллуулах журам".
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 03-р сарын 24-ны өдрийн 21 дугаар тогтоол "Иж бүрэн гудамжинд хамаарах хотын стандартыг батлах тухай".
- Төрийн өмчинь бодлого зохицуулалтын газрын 2020 оны 49, 50, 51 дүгээр тогтоол

Хамрах хүрээ:

Энэ журам нь ХӨСҮТэвийн авто зогсоолын үйлчилгээний бүхий л үйл ажиллагаанд хамаарах бөгөөд авто зогсоолоор үйлчлүүлж буй авто тээврийн хэрэгслийг, зогсоол талбайд байршуулах үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, нийт тээврийн хэрэгслийн жолооч нарт хамаарч үйлчилнэ.

2. Нэр томъёо, тодорхойлолт

3.1. Энэ журамд заасан дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "Эмнэлгийн автомашины зогсоол" гэж Тээврийн хэрэгслийг тавих үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий гадна ил задгай талбайг;

3.1.2. "Автотээврийн хэрэгсэл" гэж ачаа болон зорчигч тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн ачааны ба суудлын автомашин, автобус, чирэгч, чиргүүл хагас чиргүүлийг;

3.1.3. "Авто замын урсгал засвар" гэж авто зам, замын байгууламжийн бүрэн бүтэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, ашиглалтын түвшинг сайжруулах зорилгоор тогтмол гүйцэтгэх ажлыг;

3.1.4. "Гүйцэтгэгч" гэж эмнэлэгтэй гэрээ байгуулсны үндсэн дээр байгууллагын дотоодын авто зам, замын байгууламжийн зураг, төсөл,

барилга, засвар, арчлалт, техник, технологийн хяналтын ажлыг гүйцэтгэх эрх бүхий хуулийн этгээдийг;

3.1.5. "Байгууллагын дотоодын авто зам" гэж байгууллага өөрийн эзэмшилийн нутаг дэвсгэрт дотоодын хэрэгцээндээ зориулан барьсан авто замыг.

3. Төвийн эрх, үүрэг:

Эрх

- 3.1 Авто замын тухай, Авто тээврийн тухай хууль болон авто зогсоолын норм стандартын хэрэгжилтийг хангуулах, шаардлагатай тохиолдолд тодотгол, өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулж, шийдвэрлүүлэх;
- 3.2 Тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоолын үйлчилгээг өргөжүүлэх болон түүнтэй холбоотой техник, технологийн талаарх орон нутгийн төрийн захиргааны бодлогыг хэрэгжүүлэх;
- 3.3 Тээврийн хэрэгслийн зогсоолын жилийн төсвийг санхүү, төсвийн холбогдох хууль, тогтоомжид нийцуулэн боловсруулах;
- 3.4 Тээврийн хэрэгслийн холбогдох хууль, тогтоомжийн биелэлтийг хангуулах;
- 3.5 Төлбөртэй зогсоолын хөрөнгө оруулалт, сангийн бүрдүүлэлт, төлбөртэй зогсоолын цагийн хуваарь, үйлчилгээний үнэ, тариф, хэрэгжилтийн байдлын талаар тайлagnаж, мэдээлэх;
- 3.6 Ажилтнуудын тээврийн хэрэгслийг зогсоолд үнэ төлбөргүй тавих нөхцлийг хангах;
- 3.7 Үйлчлүүлэгчдийн аюулгүй байдал, үйлчилгээний соёлд нийцуулсэн хүн төвт үйлчилгээний горим, журмыг батлан, мөрдөх;

Үүрэг

- 3.8 Төлбөртэй зогсоолыг батлагдсан зураг, төслийн дагуу байгуулах;
- 3.9 Төлбөртэй зогсоолын үйлчилгээ эрхлэгч байгууллагад холбогдох стандарт, техникийн шаардлагыг мөрдөх шаардлага тавих, биелэлтийг хангуулах;
- 3.10 Тээврийн хэрэгслийн зогсоолын үйлчилгээ эрхлэх этгээдийг сонгон шалгаруулж, шалгарсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулах, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих;
- 3.11 Зогсоолын үйлчилгээний талбайн эрэлт, хэрэгцээг тооцож, судалгаа хийх, шинээр төлбөртэй зогсоол байгуулах шийдвэр гаргах;
- 3.12 Зогсоолын үйлчилгээг боловсронгуй болгох шаардлагатай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх.

4. Төлбөртэй зогсоолын үйлчилгээ эрхлэгчийн эрх, үүрэг:

- 4.1 Үйлчлүүлэгчдээс зогсоолын үйлчилгээ эрхлэгчтэй холбоотой хууль, дүрэм, журмыг биелүүлэх шаардлага тавих, энэхүү журамд заасан хариуцлага хүлээлгэх;
- 4.2 Зогсоолын техникийн нөхцөл, шаардлагыг хангахгүй, галын болон бусад төрлийн аюултай, даац хэтрүүлсэн тээврийн хэрэгсэлд зогсоолоор үйлчлэхээс татгалзах;
- 4.3 Хариуцаж буй зогсоолын үйлчилгээг холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу эрхлэх;
- 4.4 Төвийн зүгээс тээврийн хэрэгслийн зогсоолын үйлчилгээний чанарыг дээшлүүлэхтэй холбоотой тавьсан шаардлагыг биелүүлэх;
- 4.5 Зогсоолын төлбөрийн төхөөрөмжийг байршуулах;

- 4.6 Хэрэгжүүлэгч байгууллагад сар, улирал, жилээр үйл ажиллагааны тайлан мэдээ гаргаж өгөх;
 - 4.7 Зогсоолын тохижилтийн асуудлыг бүрэн хариуцаж, шаардлагатай засвар, үйлчилгээг цаг тухайд нь хийж гүйцэтгэж байх;
 - 4.8 Зогсоолын ажилчдыг зориулалтын хувцас, хөдөлмөрийн багаж шаардлагатай тоног төхөөрөмж болон бусад техник хэрэгслээр хангах;
 - 4.9 Зогсоолыг хашаа, хайсаар хашиж хаахгүй байх.
5. **Төлбөртэй зогсоолоор үйлчлүүлэгчийн эрх, үүрэг:**
 - 5.1 Үйлчлүүлэгч нь тээврийн хэрэгслийн техникийн нөхцөл, аюулгүй байдлын шаардлагыг хангасан зогсоолоор үйлчлүүлэх;
 - 5.2 Тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоолтой холбоотой санал, гомдол, хүсэлтийг тус төвийн Хангамж үйлчилгээ, инженер технологийн албанад хандан гаргах;
 - 5.3 Зогсоолын үйлчилгээний талаар үнэн зөв мэдээлэл авах;
 - 5.4 Үйлчлүүлэгч нь үйлчилгээний төлбөр төлсөн баримт авах;
 - 5.5 Зогсоолын техникийн нөхцөл, шаардлагыг хангасан галын болон бусад төрлийн аюулгүй, ачаа, даац хэтрээгүй тээврийн хэрэгслийг зогсоолд тавих;
 - 5.6 Үйлчлүүлэгч нь зөвхөн зогсоолын тэмдэг, тэмдэглэгээний дагуу тээврийн хэрэгслийг байрлуулах;
 - 5.7 Зогсоолын үйлчилгээний хөлсийг төлөх;
6. **Авто зогсоол түрээслэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд тавих шаардлага:**
 - 6.1 Түрээслэгч нь энэхүү стандартаар тогтоосон хөдөлгөөний болон аюулгүйн ажиллагаа, хөдөлмөр хамгаалал, галын аюулгүйн норматив, шаардлагуудыг мөрдөх;
 - 6.2 Зогсоол нь галын булан, багаж хэрэгслээр бүрэн тоноглогдсон байх;
 - 6.3 Авто зогсоолын хэвийн үйл ажиллагааг хариуцсан эзлжийн ажилтантай байх ба үйл ажиллагаа явуулахад шаардагдах хүний нөөц хангалттай байх;
 - 6.4 Авто зогсоолын хэсгийн орчин нөхцлийг сайжруулах засвар болон эмнэлгийн үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоор нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах;
 - 6.5 Автомашины зогсоолын хэсгийн улирлын чанартай цэвэрлэгээ (час, мес, навч), зам, бордюр зэргийн засварыг бүрэн хариуцах.
 - 6.6 Засвар үйлчилгээ болон цэвэрлэгээний хог хаягдлыг тухайн байгууллага еөрсдөө тээвэрлэх;
 - 6.7 Замын тэмдэг тэмдэглэлгээ бүрэн байршуулах;
 - 6.8 Шарил хадгалах тээвэрлэх үйл ажиллагааны үеэр автомашины зохицуулагч ажилтан ажиллуулж хөдөлгөөний зохицуулалт хийх;

Үйл ажиллагаа явуулахад шаардагдах тоног төхөөрөмж стандартад нийцсэн байх ба дугаар танигч камер нь тээврийн хэрэгсэл сүл зогсоолын тоо, төлбөрийн мэдээлэл харуулах дэлгэцтэй байна. Дугаар танигч камер нь тээврийн хэрэгслийг барих хурд болон дугаар таних нарийвчлал сайн сүүлийн үеийн камер байх ба шаардлагатай тохиолдолд тоног төхөөрөмжөө шинэчлэн үйл ажиллагаа явуулах;

Төвийн орох гарах хаалган дээр дугаар танигч байршуулах. Дугаар танигч нь өндер хурдтай интернет сүлжээтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Яаралтай тусламж болон эмнэлгийн бусад тусламж үйлчилгээ үзүүлэх, ажлын

бус цагаар дуудагдан ирж буй эмнэлгийн ажилтнуудад саад учруулахгүй байх нөхцөл бүрдсэн байх;

- 6.9 Төвийн үйл ажиллагаатай холбоотой ажил болон сургалт, эрдэм шинжилгээнд оролцохоор ирсэн зочдын автомашин зогсоолын төлбөр үнэгүй байх; /Тухайн зочдыг хүлээн авч буй хүмүүс урьдчилан ямар автомашин ирэх тухай зогсоолын ажилтанд мэдэгдэн бүртгүүлнэ/
- 6.10 Төвийн хэмжээнд талбайн зохицуулагч ажиллана. Зохицуулагч нь үйлчилгээний стандартын дагуу харилцаа хандлага, ёс зүйн хэм хэмжээг баримталж ажиллах;
- 6.11 Үйл ажиллагааг явуулж буй ажилтнууд нэгдсэн жигд хувцастай байх;
- 6.12 Үйлчлүүлэгчдээс ирсэн гомдол саналыг хүлээн авч хянан шийдвэрлэх;
- 6.13 Төлбөртэй зогсоолоор үйлчлүүлэгчийн эхний 30 минутын зогсоолын төлбөр үнэгүй байх;
- 6.14 Зогсоолын төлбөрийг хянах систем нь зогсоол өмчлөгчийн зэдийн хувьд нээлттэй байна.

7. Журмын хэрэгжилтийн шалгуур

- 7.1 Түрээслэгч нь сар бүрийн 30-нд ажлын тайланг Санхүү бүртгэлийн алба болон Хангамж үйлчилгээ инженер технологийн албандаа ирүүлнэ. (Тухайн сарын үйлчилгээний үзүүлэлтийг чанарын болон тоон үзүүлэлтээр тайлан гаргах)
- 7.2 Үйлчлүүлэгчдээс ирсэн гомдол саналын шийдвэрлэлтийн байдлыг сар бүр тайландаа тусгадаг байна.
- 7.3 Гадна талбайн авто зогсоол түрээслэгчийн үйл ажиллагааг доорх үнэлгээний хүснэгтээр үнэлэх ба бүлэг тус бүр 10 оноогоор үнэлэгдэнэ. Уг үнэлгээгээр 6-с доош оноогоор үнэлэгдсэн тохиололд тухайн байгууллагад сануулга бүхий мэдэгдэл хүргүүлнэ. Мэдэгдэл хүлээн авч зөрчлөө засалгүй дахин 6-с доош оноогоор үнэлэгдсэн тохиолдолд үйл ажиллагааг зогсоох хүртэл арга хэмжээ авна.

**ХӨСҮТ-ийн гадна талбайн авто зогсоолын түрээслэгчийн үйл
ажиллагааг үнэлэх үнэлгээний аргачлал**

№	Үнэлгээ	Шалгуур үзүүлэлтүүд	Суурь үнэлэх оноо	Шаардлаг а хангасан эсэх тийм / үгүй
1	Үйлчилгээний ёс зүй	Харилцааны соёл	4	
		Ажилчдын жигд хувцаслалттай байх.	3	
		Үйлчилгээг түргэн шуурхай хургэх.	3	
		Нийт	10	
2	Улирлын чанартай цэвэрлэгээ	Байгалийн хүчин зүйлсээс шалтгаалсан цас, мөс, навч болон хог хаягдлыг цаг тухайд нь тургэх шуурхай цэвэрлэх.	3	
		Цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлаа тухайн байгууллага хариуцан тээвэрлэх.	3	
		7 хоног бүрийн 5 дахь өдөр тогтсон цагийн хуваарийн дагуу түрээслэх хэсгийн замын цэвэрлэгээ хийх.	4	
		Нийт	10	
3	Шарил хадгалах тээвэрлэх үйл ажиллагааны үеэр автомашины зохицуулагч ажилтан ажиллуулж хөдөлгөөний зохицуулалт хийх	Заасан хэсгүүдэд цагийн хуваарийн дагуу зогсоолын ажилтан байршуулах.	4	
		Хөдөлгөөний зохицуулалт оновчтой хийх.	3	
		Үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж ачааллыг багасгах.	3	
		Нийт	10	
4	Хэв журам, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах	Зогсоол нь галын булан, багаж хэрэгслээр бүрэн тоноглогдсон байх.	3	
		Авто зогсоолоор үйлчлүүлж буй үйлчлүүлэгчид авто машинаа стандартын дагуу байршуулсан эсэхэд хяналт хийх.	3	
		Зогсоолд хөдөлгөөний урсгал чиглэл, хурдны хязгаарын тэмдэг тэмдэглэгээ, шугам зурvas тавьж аюулгүй байдлыг хангах	4	
		Нийт	10	